

ЭХ ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ

2026 оны 01 сарын 12 өдөр

Дугаар А/08

Улаанбаатар хот

Эмнэлзүйн заавар боловсруулах журам батлах тухай

ЭМС-ын 2022 оны 09 дүгээр сарын 09-ний өдрийн А/457 дугаар тушаал “Эмнэлзүйн заавар боловсруулах журам батлах тухай”, ЭХЭМҮТ-ийн Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдал, эрсдэлийн албаны 2025 оны хурлын дүгнэлтийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тасгийн эрхлэгч нар жил бүрийн нэгдүгээр улиралд багтаан, шинээр болон шинэчлэн боловсруулан батлуулах эмнэлзүйн зааврын жагсаалтаа гаргаж, хариуцсан дэд захирлаар хянуулан, төвийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд оруулан батлуулсугай.

2. Тасгийн эрхлэгч бүр эмчлэгдэх өвчний батлагдсан жагсаалтын дагуу оношилгоо, эмчилгээний улсын стандарт, Эрүүл мэндийн сайд, төвийн захирлаар батлуулсан эмнэлзүйн зааврын тулгалт хийж, стандарт, эмнэлзүйн зааврын хангалтын хувийг жил бүр тооцон гаргасугай.

3. Ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх зарчмыг баримтлан, эмнэлзүйн заавар боловсруулах багийг томилон ажиллуулж, боловсруулсан зааврыг зөвлөх эмч, Эмнэлзүй эрхэлсэн дэд захирлаар хянуулан, төвийн захирлаар батлуулан ажиллахыг Эмнэлзүй эрхэлсэн дэд захирлууд (Л.Ганбаяр, Г.Баттулга), Сувилахуй эрхэлсэн дэд захирал (Б.Болорхорлоо) нарт тус тус даалгасугай.

4. Батлагдсан эмнэлзүйн зааврын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдал, эрсдэлийн албаны дарга (А.Оюунчимэг)-д даалгасугай.

5. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хүний нөөцийн албаны дарга (түр орлон гүйцэтгэгч Н.Мөнхшүр)-д даалгасугай.

ЗАХИРАЛ



Ж.ОТГОНБААТАР

1606060028

ЭМНЭЛЗҮЙН ЗААВАР БОЛОВСРУУЛАХ ЖУРАМ

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

- 1.1 Эмнэлзүйн зааврыг шинээр боловсруулах, шинэчлэхдээ оношилгоо, эмчилгээний нотолгоонд тулгуурласан, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн, шинэлэг арга, туршлага, эрүүл мэндийн технологийн үнэлгээний дүнд үндэслэнэ.
- 1.2 Эмнэлзүйн заавар гэдэг нь аливаа өвчин, эмгэгийг оношлох, эмчлэхэд ашиглах аргыг нотолгоонд суурилсан анагаах ухаанд тулгуурлан, зохион байгуулалт, дэс дараалалтайгаар нарийвчлан заасан нэгдмэл мэдээлэл бүхий баримт бичиг юм.
- 1.3 Эмчилгээ, оношилгооны шинэ технологи, арга, аргачлал нэвтрүүлэхдээ эмнэлзүйн заавар батлуулсан байна.
- 1.4 Эмнэлзүйн заавар боловсруулахдаа нотолгоонд суурилсан, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн заавар, стандартыг суурь болгон ашиглана.
- 1.5 Өвчний хэлбэр, үйлчлүүлэгчийн биеийн байдал, эмчилгээний онцлогоос хамаарах оношилгоо, эмчилгээний зайлшгүй хийх тусламж, үйлчилгээ, гүйцэтгэх ажилбар, гардан үйлдэл, зөвлөгөөг эмнэлзүйн зааварт тусгана.
- 1.6 Оношилгоо, эмчилгээ, сэргээн засах, хэрэглэх эм, эмнэлгийн хэрэгслийг тодорхой нарийвчлан зааж, эм, биобэлдмэлийг олон улсын нэршлээр бичнэ.
- 1.7 Эмнэлзүйн зааврыг олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн шинэ технологи, арга туршлага нэвтэрсэн тухай бүрд судлан шинэчилнэ.
- 1.8 Эмнэлзүйн зааварт хэрэглэгдэж байгаа мэргэжлийн үг хэллэг, нэр, томъёо нь хоёрдмол утга санаагүй, ойлгогдохуйц байна.

ХОЁР. ЭМНЭЛЗҮЙН ЗААВАР БОЛОВСРУУЛАХ ЗАГВАР

А. ЕРӨНХИЙ ШААРДЛАГА

- А.1. Онош эсвэл хам шинж
- А.2. Өвчний олон улсын 10 дугаар ангилал болон үйлдлийн олон улсын 9 дүгээр ангилал
- А.3. Хэрэглэгчид
- А.4. Зааврын зорилго, зорилт
- А.5. Тодорхойлолт
- А.6. Тархвар зүйн мэдээлэл
- А.7. Үндсэн ойлголт
- А.8. Өвчний тавилан
- А.9. Үйлчлүүлэгчид өгөх зөвлөгөө
- А.10. Эрсдэлт хүчин зүйлс

Б. УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭЛТ, ЭРТ ИЛРҮҮЛЭГ

- Б.1. Эрүүл мэндийн анхан шатны болон лавлагаа тусламж, үйлчилгээ бүрт эрт илрүүлэг зохион байгуулах
- Б.2. Зорилтот бүлэг
- Б.3. Эрт илрүүлгийн өмнөх зөвлөгөө
- Б.4. Эрт илрүүлэг хийх арга техник

В. ОНОШИЛГОО, ЭМЧИЛГЭЭНИЙ ДЭС ДАРААЛАЛ /АЛГОРИТМ/

- В.1. Эмнэлэгт хэвтэх заалт

- В.2. Зовиур, эмнэлзүйн шинж
- В.3. Ерөнхий болон бодит үзлэг, багажийн шинжилгээ
 - В.3.1. Дурдатгал /анамнез/
 - В.3.2. Бодит үзлэг
 - В.3.3. Эрэмбэлэн ангилалт, яаралтай тусламж үзүүлэх шалгуур
 - В.3.4. Лабораторийн шинжилгээ
 - В.3.5. Багажийн шинжилгээ
 - В.3.6. Оношилгооны шалгуур
 - В.3.7. Ялган оношилгоо
- В.4. Шинжилгээний хариу өөрчлөлттэй гарсан үйлчлүүлэгчийг хянах аргазүй
 - В.4.1. Лабораторийн шинжилгээний хариу өөрчлөлттэй гарсан үеийн алгоритм
 - В.4.2. Багажийн шинжилгээний хариу өөрчлөлттэй гарсан үеийн алгоритм
- В.5. Оношилгоонд шаардлагатай зурган жишээ
- В.6. Эмчилгээ
 - В.6.1. Эмийн бус эмчилгээ /заалт, эмчилгээ үргэлжлэх хугацаа, хүндрэл, анхаарах заалт/
 - В.6.2. Эмийн эмчилгээ /эмийн нэрийг олон улсын нэршлээр бичнэ. Нэгдүгээр сонголтын эм, дараагийн сонголтын эмийн тун хэмжээ, тун хоорондын зай, эмчилгээ үргэлжлэх хугацаа, анхаарах заалт, хоруу нөлөөний тухай мэдээлэл/
 - В.6.3. Мэс засал эмчилгээ /Заалт, нөхцөл, бэлтгэл, арга техник, мэс заслын өмнө, явцад болон дараа тавих хяналт/
 - В.6.4. Эмчилгээний алгоритм
- В.7. Үйлчлүүлэгчийг эмнэлгээс гаргах заалт
- В.8. Амбулаторийн хяналт хийх хугацаа
- В.9. Зааврын хэрэгжилтийг үнэлэх хяналтын хуудас
- В.10. Үйлчлүүлэгчийг дараагийн шатны эмчид илгээх зарчим, шалгуур
- В.11. Эмнэлзүйн хөтөч

Г. ХЯНАЛТ

- Г.1. Ерөнхий ойлголт
- Г.2. Эмчилгээний дараах анхан, лавлагаа шатлалын эмчийн хяналтад байх хугацаа
- Г.3. Анхан шатны эрүүл мэндийн байгууллагад үйлчлүүлэгчийг хянахад анхаарах асуудлууд
- Г.4. Яаралтай шинж илэрвэл эмнэлэгт хандах мэдээлэл
- Г.5. Үйлчлүүлэгчид олгох эрүүл мэндийн боловсрол, зөвлөгөө

Д. ЗААВАР БОЛОВСРУУЛАХАД АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖУУД